

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН БУЯНТ-УХАА ДАХЬ ГАЗРЫН 2018 ОНЫ ДОЛООДУГААР САРД
ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ
/2018.06.16 - 2018.07.25/

2018 оны 07 дугаар сарын 26

Буянт-Ухаа

Д/д	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин	Биелэлт	Хариуцах албан хаагч	Хувь
1	2	3	4	5	6	7
1.	Газрын үйл ажиллагааны чиглэлээр	Төслийн хэмжээнд бэлтгэсэн хилийн боомтын өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглагдах үг хэллэгийг агуулсан англи-монгол хэлний ярианы дэвтрийг хэвлүүлэх ажлын зохион байгуулах	Англи-монгол хэлний гарын авлага хэвлүүлсэн байна.	Тасарсан.	Хяналтын улсын байцаагч	0
2.		Буянт-Ухаа дахь газрын үйл ажиллагааны талаарх статистик мэдээ агуулсан эмхэтгэлийн төсөлд баяжилт хийх.	Хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой тоо мэдээллийг нэмж тусгасан байна.	ГИХГ-ын Буянт-Ухаа дахь газар нь дотоод үйл ажиллагаандаа ашиглах зорилгоор тус газрын үйл ажиллагааны талаарх статистик мэдээ агуулсан эмхэтгэлийн төслийг бэлтгэсэн бөгөөд тус газрын даргаас өгсөн үүргийн дагуу хүний нөөцтэй холбоотой 2016, 2017, 2018 оны /2018 оны тоон мэдээг эхний хагас жилийн байдлаар тусгасан бөгөөд жилийн эцсээр тоог шинэчилнэ/ тоон мэдээлэл болох орон тоо, мэргэжил, боловсрол, нас, хүйс, гадаад сургалт, шагнал, сахилга, цалин хөлсний талаарх мэдээллийг нэмж тусган.	Хяналтын улсын байцаагч нар, Захиргааны ахлах мэргэжилтэн	100

1	2	3	4	5	6	7
3.	Дээд шатны байгууллагыг мэдээллээр хангах чиглэлээр	Газрын үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэж Гадаадын иргэн, харьяатын газрын холбогдор нэгжид хугацаанд нь хүргүүлэх.	Захиргаа, Төв аймаг дахь төлөөлөл, боомтод ажиллаж буй 4 ээлжээс хийсэн ажлын тайлан, төлөвлөгөөний биелэлт, хийх ажлын төлөвлөгөөг байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасан хугацаанд авч, нэгтгэн ГИХГ-ын Боомт, орон нутгийн хэлтэст хүргүүлсэн байна.	Захиргаа, боомтод ажиллаж буй 4 ээлжээс энэ оны наймдугаар сард хийх үндсэн арга хэмжээний төлөвлөгөөнд тусгах саналыг авч нэгтгэн 2018.07.25-ны өдөр, долоодугаар сард хийх үндсэн арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн 2018.07.26-ны өдөр цахимаар ГИХГ-ын Боомт, орон нутгийн хэлтэст хүргүүлсэн. Түүнчлэн энэ оны долоодугаар сард хийсэн ажлын тайланг нэгтгэн ГИХГ-ын Боомт, орон нутгийн хэлтэст 2018.07.25-ны өдөр 12/77 дугаар албан бичгээр хүргүүлсэн.	Захиргааны ахлах мэргэжилтэн	100
4.	Дээд шатны байгууллагыг мэдээллээр хангах чиглэлээр	Байгууллагын инфографик мэдээнд тусгах статистик тоог гаргаж холбогдох нэгжид хүргүүлэх ажлыг зохион байгуулах.	Тоон мэдээг 2017 онтой харьцуулан гаргаж Боомт, орон нутгийн хэлтэст хүргүүлсэн байна.	Гадаадын иргэн, харьяатын газраас гаргадаг инфографик мэдээнд тусгах Буянт-Ухаа дахь газрын 2018 оны 07 дугаар сарын статистик тоог 2017 оны мөн үетэй харьцуулан гаргаж Боомт, орон нутгийн хэлтэст 2018.07.25-ны өдөр цахимаар хүргүүлсэн болно. Тухайлбал, 2017.06.16-2017.07.25-ны өдрийн байдлаар тус газарт ирсэн бичиг 16 /харицтай албан бичиг 8/, явсан бичиг 14, ирсэн өргөдөл 2, гомдол 0 байсан бол 2018.06.16-2018.07.25-ны өдрийн байдлаар тус газарт ирсэн бичиг 15 /хариутай албан бичиг 2/, явсан бичиг 9, ирсэн өргөдөл 4, гомдол 0 байна.	Захиргааны ахлах мэргэжилтэн	100

1	2	3	4	5	6	7
5.		Байгууллагын даргын батлан гаргасан албан даалгаврын биелэлтийг гаргаж холбогдох нэгжид хүргүүлэх ажлыг зохион байгуулах.	Биелэлтийг үнэн зөв гаргаж Боомт, орон нутгийн хэлтэст хүргүүлсэн байна.	Байгууллагын даргын батлан гаргасан албан даалгаврын биелэлтийг цаг тухайд нь гарган төвд тогтоосон хугацаанд хүргүүлсэн. Тухайлбал, төвөөс өгсөн чиглэлийн дагуу биелэлт гаргах шаардлагатай 2017 оны 03, 05, 06, 2018 оны 01, 02, 03, 04, 05, 06, 07, 09 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг гаргаж БОНХ-т 2018.06.11-ний өдөр болон мөн сарын 18-ны өдөр хүргүүлсэн.	Нийт албан хаагчид	100
6.		Гадаадын иргэн, харьяатын газраас батлан гаргасан үйл ажиллагаатай холбоотой төлөвлөгөөний хэрэгжилтийг гаргаж холбогдох нэгжид хүргүүлэх.	Тус газартай холбоотой заалт тус бүрийн биелэлтийг гаргаж холбогдох нэгжид хүргүүлсэн байна.	Төсвийн ерөнхийлөн захирагчтай 2018 онд байгуулсан төсвийн төвлөрүүлэн захирагчийн үр дүнгийн гэрээний дагуу энэ оны төлөвлөгөөнд туссан тус газартай холбоотой арга хэмжээний биелэлтийг гаргаж 2018.06.11-ний өдөр, ГИХГ-ын сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах талаар 2018 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд туссан тус газартай холбоотой заалтын биелэлтийг гаргаж 2018.06.18-ны өдөр тус тус БОНХ-т, ГИХГ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2018 оны төлөвлөгөөний хоёрдугаар улирлын тус газартай холбоотой заалтын хэрэгжилтийг гаргаж 2018.06.25-ны өдөр ДШДАХ-т хүргүүлж ажиллалаа.	Захиргааны ахлах мэргэжилтэн	100

1	2	3	4	5	6	7
				Түүнчлэн ДШДАХ-ээс ирүүлсэн 01 дүгээр зөвлөмжийн ГИХГ-ын Буянт-Ухаа дахь газартай холбоотой заалтын хагас жилийн хэрэгжилтийг гаргаж 2018.07.17-ны өдөр БОНХ-т хүргүүлсэн.		
7.	Виз, бүртгэлийн чиглэлээр	Гадаадын иргэнд виз олгох, визний шилжүүлэг хийх, бүртгэл, хасалтын үйлчилгээ үзүүлэх.	Төрийн үйлчилгээг гадаадын иргэнд түргэн шуурхай үзүүлсэн байна.	Нийт 105 орны 1508 гадаадын иргэнд зохих ангилал, зориулалтын визийг олгосон бөгөөд визийн шилжүүлэг 27 хийсэн байна. Үүнд, нэг удаагийн орох 1462, хоёр удаагийн орох 3, олон удаагийн орох 16, нэг удаагийн гарах-орох 18, хоёр удаагийн гарах-орох 0, олон удаагийн гарах-орох 9, дамжин өнгөрөх 0, түр ирэгчийн бүртгэл, хасалт 115, оршин суух зөвшөөрлийн хасалт 35, визийн засвар 6, хүчингүй болгосон виз 9 байна.	Виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн, Хяналтын улсын байцаагч нар	100
8.		Монгол Улсын визгүй, хориг арга хэмжээ авагдсан гадаадын иргэнийг буцаах арга хэмжээ авч ажиллах.	Гадаадын иргэний мэдээллийг “ISM” систем дээр шалгаж визгүй, хориг арга хэмжээтэй гадаадын иргэнийг хил нэвтрүүлэлгүй буцаасан байна.	Гадаадын иргэний мэдээллийг “ISM” систем дээр шалгаж Монгол Улсын виз, визийн зөвшөөрөлгүй зэрэг үндэслэлээр БНЭУ-3, БНАСАУ-1, Катар-1, Харьялалгүй-1, нийт 6 гадаадын иргэнийг хилээр оруулаагүй буцаасан ба гарах визгүй, аж ахуйн нэгжийн албан бичиггүй зэрэг үндэслэлээр Хятад-6, Турк-1, Польш-1, Америк-2, Ирланд-1, Дани-1, Австрали-1, Канад-1, Катар-1, нийт 15 гадаадын иргэнийг хилээр гаргаагүй болно.	Виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн, Хяналтын улсын байцаагч нар	100

1	2	3	4	5	6	7
9.	Хяналт шалгалтын чиглэлээр	Төв аймагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгуулагад хөдөлмөр эрхэлж байгаа гадаадын иргэдэд хяналт шалгалт хийх.	Удирдамж батлуулан хяналт шалгалтыг зохион байгуулж, дүнг Буянт-Ухаа дахь газрын даргад танилцуулсан байна.	<p>Байгууллагын даргын 2018.07.18-ны өдөр баталсан УБ-02/2018-006 дугаартай удирдамжийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг тус газрын 4 албан хаагч GB1 ангиллаар тус улсад оршин суух зөвшөөрөл хүссэн БНСУ-ын 1 иргэний бодит байдлыг тогтоох зорилгоор оршин суугаа хаягаар 2018.07.23-ны өдөр очиж, баримт бичгийг шалгасан бөгөөд дүгнэлтээ төвд хүргүүлсэн болно. Түүнчлэн Гадаадын иргэн, харьяатын газрын Буянт-Ухаа дахь газрын даргын баталсан БУ2018-08 дугаартай удирдамжийн хүрээнд төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2018.07.24-ний өдөр Төв аймгийн Эрдэнэ, Ар хуст, Баянжаргалан, Баян, Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт байрлах Ногоон сор, Ногоон тэнгэр, Мөнхийн баян гал, БНДА компани болон Бөөрөлжүүтийн уурхайд хийж нийт 123 гадаадын иргэний бичиг баримт шалгалаа.</p> <p>Хяналт шалгалт явуулсан талаарх илтгэх хуудсыг тус газрын даргад танилцуулахаар ажиллаж байна.</p>	Хяналтын улсын ахлах байцаагч, Хяналтын улсын байцаагч нар	70

1	2	3	4	5	6	7
10.		Зөрчлийн тухай хуулийн дагуу ГИЭЗБТХууль зөрчсөн гадаадын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын зөрчлийг арилгаж, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллах.	Зөрчил гаргасан гадаадын иргэн, ААН, байгууллагын зөрчлийг шийдвэрлэж, зөвлөгөө мэдээлэл өгсөн байна.	Бүртгэлийн талаар тогтоосон журам зөрчсөн, визийн хугацаа хэтрүүлсэн, оршин суух журам зөрчсөн зэрэг үндэслэлээр 30 гадаадын иргэнд 2,720,000 төгрөг, 9 ААН-д /хамрагдсан гадаадын иргэн 41/ 12,990,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, зөрчлийг арилган, зөвлөгөө мэдээлэл өгөв.	Хяналтын улсын ахлах байцаагч, Хяналтын улсын байцаагч нар	100
11.		Хууль тогтоомж зөрчсөн гадаадын иргэнийг илрүүлсэн тохиолдолд Монгол Улсаас албадан гаргах үйл ажиллагааг зохион байгуулах.	Холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч, мэдээллийн нэгдсэн санд бүртгэл хийсэн байна.	Төлөвлөгөөт хугацаанд холбогдох хууль тогтоомжийн дагуу албадан гаргагдах гадаадын иргэн илрээгүй тул тус газраас албадан гаргасан гадаадын иргэн байхгүй болно.	Хяналтын улсын ахлах байцаагч, Хяналтын улсын байцаагч нар	100
12.		Визгүй зорчдог болон хоригт багтсан орны иргэдэд хил дээр тавих хяналтыг сайжруулж ажиллах.	Хил дээр тавих хяналт сайжирсан байна.	Монгол Улсад визгүй зорчигч болон хоригт багтсан гадаадын иргэн, хөдөлмөр эрхлэх магадлалтай 8 орны 154 иргэнтэй ярилцлага хийж бичиг баримтыг хуулбарлан хилээр гарсан байдалд хяналт тавьж бүртгэл хөтөлсөн болно. Үүнд: Украин-10, Киргиз-17, Филиппин-91, Казакстан-25, Вьетнам-6, Тайланд-1, БНЭУ-2, БНАСАУ-2.	Хяналтын улсын ахлах байцаагч, Хяналтын улсын байцаагч нар	100
13.	Хүний нөөц, сургалтын чиглэлээр	Нэг бүрийн тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх арга зүйн сургалт зохион байгуулах.	Хяналтын улсын байцаагчид бие хамгаалах урлагт суралцаж, аюулгүй байдал хангагдсан байна.	Тус газрын 10 хяналтын улсын байцаагч нарт 2018.07.23-ны өдөр нэг бүрийн тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх арга зүйн сургалтыг Иргэний агаарын тээвэр дэх Цагдаагийн хэлтэстэй хамтран зохион байгуулав.	Хяналтын улсын ахлах байцаагч	100

1	2	3	4	5		
				<p>Тус сургалтаар хяналтын улсын байцаагч нарт нэг бүрийн тусгай хэрэгсэл болох гав, резинэн бороохой, хамгаалах тусгай хэрэгсэл болох нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, бие хамгаалах урлагийн зэвсэггүйгээр тулалдах мэх болох боох мэх, тонгор мэх, өчих мэх, хутга мэс хариулах мэх, бие хамгаалах хариу цохилт хийх арга зүйн талаар зааж сургав.</p>		
14.		<p>“Байгууллагын аюулгүй байдлыг хангахад анхаарах зүйл” сэдвээр мэдээлэл, сургалт зохион байгуулах</p>	<p>Албан хаагчид байгууллагын аюулгүй байдлыг хангах талаар мэдлэгтэй болсон байна.</p>	<p>Тус газар 2018.06.25-ны өдөр нийт 23 албан хаагчдад “Байгууллагын аюулгүй байдлыг хангахад анхаарах зүйл” сэдвээр мэдээлэл хийлээ. Тухайлбал, байгууллагын үйл ажиллагаанд ашигладаг “ISM” програм, байгууллагын нууцад хамаарах зүйлсийн талаар мэдээлэл хийж хадгалалт, хамгаалатыг хангаж ажиллах талаар анхааруулав. Үүнээс гадна хөдөлмөрийн аюулгүй байдлын талаарх зааварчилгаатай албан хаагчдыг өдөр бүр танилцуулж, гарын үсэг зуруулан ажиллаж байна.</p>	<p>Виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн</p>	100

1	2	3	4	5	6	7
15.		“Терроризмтой тэмцэх ажлыг зохион байгуулах” сэдвээр мэдээлэл, сургалт зохион байгуулах	Албан хаагчид терроризмтой тэмцэх талаар мэдлэгтэй болсон байна.	Тус газар 2018.06.25-ны өдөр “Терроризмтой тэмцэх ажлыг зохион байгуулах” сэдвээр нийт 23 албан хаагчдад сургалт зохион байгуулав. Сургалтаар тус газрын албан хаагчид Монгол Улсын терроризмтой тэмцэх тогтолцоо, олон улс болон Монгол Улсын терроризмын өнөөгийн нөхцөл байдал зэргийн талаар мэдээлэл авч, харилцан ярилцлаа.	Виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн	100
16.		Тус газарт шинээр томилогдон ирсэн албан хаагчийн талаарх мэдээллийг Төрийн албаны зөвлөлийн програмд шивж оруулах	Төрийн албаны зөвлөлийн цахим програмд баяжилт хийсэн байна.	Байгууллагын даргын 2018 оны Б/188, Б/190 дүгээр тушаалаар Буянт-Ухаа дахь газарт хяналтын улсын байцаагч, мэргэжилтнээр шилжүүлэн томилсон 2 албан хаагчийн талаарх мэдээллийг Төрийн албаны зөвлөлийн цахим програмд оруулсан.	Захиргааны ахлах мэргэжилтэн	100
17.	Санхүү, хангамжийн чиглэлээр	Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, өр авлагагүй ажиллах.	Төсөв санхүүгийн үр ашигтай тогтолцоог бүрдүүлэн ажилласан байна.	Батлагдсан төсвийг зохих зардлын дагуу зарцуулан өр, авлагагүй ажилласан. Батлагдсан төсөв болох өссөн дүнгээр 330,417,200 төгрөгийн санхүүжилт орсноор цалин хөлсөнд 183,287,297 төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэл 20,947,690 төгрөг, ХУД-т цалин хөлснөөс суутгасан ашгийн татварт 13,857,440 төгрөг, хангамж, бараа материалын зардалд 15,422,000 төгрөг зарцуулж өглөг авлага үүсгээгүй ажилласан.	Ахлах нягтлан бодогч	100

1	2	3	4	5	6	7
18.		Буянт-Ухаа дахь газрын 2018 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг нэгтгэн гаргаж, холбогдох нэгжид хүргүүлэх ажлыг зохион байгуулах.	Тайланг үнэн зөв гаргаж, ГИХГ-ын Санхүүгийн хэлтэст хүргүүлсэн байна.	Тус газрын 2018 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг нэгтгэн гаргаж ГИХГ-ын Санхүүгийн хэлтэст 2018.07.10-ны өдөр хүргүүлсэн.	Ахлах нягтлан бодогч	100
19.		Төсвийн гүйцэтгэлийн мэдээ тайланг үнэн зөв гарган тогтоосон хугацаанд тайлагнах.	НД-ын шимтгэлийн тайланг дараа сарын 5, төсвийн гүйцэтгэлийн тайланг дараа сарын 2-ны өдрийн дотор гаргаж төсөв санхүүгийн үр ашигтай тогтолцоо бүрдсэн байна.	Төсвийн гүйцэтгэлийн мэдээг 2018.07.02-ны дотор гарган ХУД-ийн төрийн сангаар баталгаажуулан ГИХГ-ын Санхүүгийн хэлтэст хүргүүлсэн. Мэдээгээр 281,223,900 төгрөгийн урсгал санхүүжилт орсоноос нийт зарлага 227,494,462 төгрөгийн ажил үйлчилгээ явуулж өглөг авлагагүй ажилласан. НДШ-ийн тайланг гарган 2018.07.05-ны дотор НДХ-т хүргүүлэн 20,947,690 төгрөгөөр тооцоо нийлэв.	Ахлах нягтлан бодогч, Нярав	100
20.		Үнэт цаасны тооцоо, авто машин ашиглалтын болон шатах тослох материалын тооцоог хугацаанд нь гаргаж, бүртгэл хөтлөн ажиллах.	Бүртгэл тооцоо хугацаандаа чанартай хийгдсэн байна.	Албан хаагчдад үнэт цаас болох визийн хуудас 600 ширхэгийг шаардах хуудасны дагуу олгосон. Түүнчлэн авто машины ашиглалт болон шатах тослох материалын тооцоог жолооч дэвтэрт бичилтийг хийн бүртгэл хөтлөв.	Ахлах нягтлан бодогч	100
21.		Төсвийн хүрээнд худалдан авалт хийх, албан хаагчдын ажиллах нөхцлөөр хангаж ажиллах.	Шаардлагатай бараа материалын худалдан авалт хийж шаардах хуудасны дагуу бараа материалыг тухай бүр нь гаргаж өгсөн байна.	Хангамж, бараа материалын зардалд өссөн дүнгээр 15,422,083 төгрөгийн худалдан авалт хийж, албан хаагчдыг шаардлагатай бараа материалаар хангаж ажилласан.	Ахлах нягтлан бодогч, Нярав	100

1	2	3	4	5	6	7
22.		Албан хэрэгцээнд ашиглаж буй суурин утас, шуудангийн болон боомтод байрлах албан хаагчдын ажлын байрны түрээсийн төлбөр тооцоог нэхэмжлэхийн дагуу тухай бүр шийдвэрлэх.	Нэхэмжлэхийн дагуу тухайн байгууллагын холбогдох дансруу шилжүүлэн өглөг авлагагүй ажиллана.	Албан хэрэгцээнд ашиглаж байгаа суурин утас болон интернетийн төлбөрт 2,042,700 төгрөг, байрны түрээс 10,660,000 төгрөг харилцагч байгууллагын нэхэмжлэхийн дагуу холбогдох данс руу шилжүүлсэн.	Ахлах нягтлан бодогч	100
23.		Татварын улсын тэмдэгтийн хураамж, хүү, торгуулийн тайланг гаргаж тооцоо нийлэх.	Хяналтын улсын байцаагч нараас тайланг авч тулган, сар бүрийн 5-ны дотор төвд хүргүүлсэн байх.	Энэ оны 07 дугаар сарын 05-ны өдрийн дотор хүү торгууль 13,830,000 төгрөгийг Төв аймгийн төрийн санд, визийн тэмдэгтийн хураамж 191,783,440 төгрөг, визийн хуудас 25,337,390 төгрөгөөр тайлан нэгтгэн Хяналтын улсын байцаагч нартай тооцоо нийлэн ГИХГ-ын Санхүүгийн хэлтэст хүргүүлсэн.	Ахлах нягтлан бодогч	100
24.		Бараа материалын тайлан, кассын тайланг тухай бүр гаргах.	Нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу анхан шатны баримтыг бүрдүүлэн ажилласан байна.	Бараа материалын болон шатахууны тайланг гаргахдаа Нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу анхан шатны баримтыг бүрдүүлэн гаргасан ба хянуулж баталгаажуулсан. Түлш шатах тослох материалын тайлан өссөн дүнгээр 9,997,200 төгрөгний зарцуулалт гаргаж тайлагнасан.	Ахлах нягтлан бодогч, Нярав	100
25.		Газрын албан хаагчдын нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын дэвтэрт холбогдох бичилтийг хийх.	Албан хаагчдын НДД, ЭМД-ын дэвтэрт бичилт хийж нийгмийн даатгалын байцаагчаар НДД-ийг баталгаажуулсан байна.	Тус газрын нийт 28 албан хаагч, хүүхэд асрах чөлөөтэй 2 албан хаагчийн нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын дэвтэрт холбогдох бичилтийг хийж Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээр баталгаажуулав.	Нярав	100

1	2	3	4	5	6	7
26.	Өргөдөл, гомдлын чиглэлээр	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас өргөдөл, гомдол гаргах бүрт бүртгэл хөтлөн, холбогдох албан хаагчид хүргүүлж, хуульд заасан хугацаанд шийдвэрлүүлэх.	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан хаагчаас гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авч, хуульд заасан хугацаанд шийдвэрлүүлсэн байна.	Тус газрын 4 албан хаагчаас ирүүлсэн өргөдлийг хүлээн авч шийдвэрлэн, хариуг хүргүүлсэн бол иргэн, ААН, байгууллагаас гаргасан өргөдөл, гомдол байхгүй болно. Тухайлбал, ирсэн 4 өргөдөлд Байгууллагын даргын 2018 оны Б/202 дугаар тушаалын дагуу 1 албан хаагчид 13 хоногийн цалингүй чөлөө олгосон бол тус газрын даргын 2018 оны А/16 дугаар тушаалын дагуу 1 албан хаагчид нэг сарын албан тушаалын цалинг нэг удаа олгосон ба мөн оны А/17, А/18 дугаар тушаалын дагуу 2 албан хаагчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх мөнгөн тусламж тус тус олгосон байна.	Захиргааны ахлах мэргэжилтэн	100
27.	Бичиг хэрэг, архивын үйл ажиллагааны чиглэлээр	Газарт ирсэн, явсан албан бичгийн бүртгэл хөтөлж, хариутай албан бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллах.	Ирсэн, явсан бичгийн бүртгэлийг хөтөлжсөн хариутай албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлсэн байна.	Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын дагуу тус газарт ирсэн нийт 15 албан бичгийг цаасан болон цахим хэлбэрээр бүртгэж, Бүртгэл-хяналтын карт хөтлөн, газрын даргад танилцуулан цохолт хийлгэж, холбогдох албан хаагчид шилжүүлэн шийдвэрлэлтийн байдалд хяналт тавин ажиллалаа. Хариутай 2 албан бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавин ажилласан ба 9 албан бичиг боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлэв.	Захиргааны ахлах мэргэжилтэн	100

1	2	3	4	5	6	7
28.		Тус газарт ирсэн, явсан албан бичиг, тус газрын даргын баталсан тушаалыг сканердаж цахим архив үүсгэх.	Ирсэн, явсан албан бичиг, тус газрын даргын баталсан тушаалыг сканердаж цахим архив үүсгэсэн байна.	Тус газрын цаасан суурьтай баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд Буянт-Ухаа дахь газрын даргын батлан гаргасан 4 тушаал, тус газарт ирсэн 15, явсан 9 албан бичиг, тус газрын энэ сарын төлөвлөгөө, түүний биелэлт, тайланг сканердаж цахим хэлбэрт шилжүүлсэн.	Захиргааны ахлах мэргэжилтэн	100
29.	Мэдээллийн технологийн чиглэлээр	Сүлжээний тасралтгүй үйл ажиллагааг ханган ажиллах.	Ирсэн дуудлагын дагуу засвар үйлчилгээг хийж хэвийн ажиллагаанд оруулсан байна.	Сүлжээний болон техник хэрэгслийн нийт 14 дуудлага хүлээн авч засварласан. "ISM" системийн сүлжээ 2 удаа тасарсан ба тухай бүр холбогдох байгууллагын систем хариуцсан инженертэй холбогдон мэдээлэл авч, сүлжээг хурдан шуурхай хэвийн байдалд шилжүүлэн ажилласан. Үндэсний их баяр наадмын өдрүүдэд тус газрын даргын баталсан хуваарийн дагуу ажилласан бөгөөд Буянт-Ухаа боомтод 2018.07.11-ний өдрөөс 15-ны өдрийн хооронд сүлжээний доголдол болон техник хэрэгслийн гэмтэл гараагүй, хэвийн ажилласан ба энэ талаар тухай бүр төвийн сүлжээний инженерт мэдэгдэв.	Сүлжээний инженер	100

1	2	3	4	5	6	7
				Түүнчлэн “Чингис хаан” олон улсын нисэх буудал дахь тус газрын харьяа өрөөний хананаас салсан байсан тог дамжуулах залгуурыг цахилгааны албанд дуудлага өгөн засварлуулж аюулгүй байдлыг хангасан.		
30.	Олон нийттэй харилцах чиглэлээр	Төсвийн зарцуулалтын талаар Shilendans.gov.mn сайтад мэдээллийг тухай бүр оруулж, иргэд хүссэн мэдээллээ авах боломжийг бүрдүүлэх.	Шилэн дансны хуулийн хэрэгжилт болон төсвийн ил тод байдлыг ханган ажиллаж, мэдээг үнэн зөв оруулсан байна.	Төсвийн зарцуулалтын талаар Shilendans.gov.mn сайтад мэдээллийг шивж оруулсан. Тухайлбал, Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл, Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг байршуулсан.	Ахлах нягтлан бодогч	100

1	2	3	4	5	6	7
				<p>Үүнээс гадна Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл шивж оруулсан.</p>		

Төлөвлөсөн: 30
Биелсэн: 28
Хагас биелсэн: 1
Биелээгүй: 1
Хувь: 96